

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2017 оны 46 дугаар тогтоолын хавсралт



“ЧАДВАРЛАГ ХОВДЧУУД” ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын баримт бичигт: Үндэсний хөгжлийн цогц бодлогын зорилт нь ... Хүнийг оюунжуулж, чадваржуулах замаар мэдлэгт суурилсан эдийн засагтай болох, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын зорилгыг иргэн бүр авьяас, чадвараа хөгжүүлэн, үр бүтээлтэй хөдөлмөрлөж, аз жаргалтай амьдрахад шаардагдах мэдлэг, чадвар, чадамжийг эзэмшин, ёс суртахуун, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахиж, үндэсний нийтлэг үнэт зүйлсийг өвлөн насан туршдаа суралцах боломжоор хангах зорилго бүхий үйл ажиллагааны цогц тогтолцоо бүрдүүлэх хэмээн тодорхойлсон байдаг.

Өнөөгийн боловсролын салбарыг хөдөлмөрийн зах зээлээ дэмжих чадвар сул, ажиллах хүн хүчний нөөцийг бүрэн бүрдүүлэх чадамжгүй, суралцагчдын иргэний төлөвшлийг хангалттай түвшинд хүргэж чаддаггүй гэж дүгнэсээр байгаа юм.

Даяаршил, шинжлэх ухаан, технологийн дэвшлийн эрин үе нь нээлттэй, өрсөлдөөнтэй, мэдээлэлжсэн орчинд амьдрах чадварыг хүн бүрээс шаардах боллоо.

Иймд “Чадварлаг Ховдчууд” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр өсвөр үеийнхнийг өөртөө итгэлтэй, шийдвэр гаргах чадвартай, бие бялдар, оюун сэтгэхүй, ёс суртахууны төлөвшилтэй хувь хүн болж хөгжихөд эцэг эх, төрийн үүрэг, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, багш, хүүхдийг бүх талаар хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Хүүхэд бүрийн авьяас, чадварыг нээн хөгжүүлснээр бага наснаасаа мэргэжлийн чиг баримжаатай болж, улмаар хийж бүтээх, ажил, мэргэжлээ зөв сонгон, цаашид эзэмшсэн мэргэжлээрээ үр бүтээлтэй хөдөлмөрлөж, сайхан амьдрах цогц мэдлэг, чадвартай иргэн болж төлөвших нөхцөл бололцоо сайжирна.

Хүмүүнлэг иргэний, ардчилсан нийгэм байгуулах эрхэм зорилгын хүрээнд өсвөр үеийнхний нийтлэг сайн сайхан байдал, хүүхэд нэг бүрийн хөгжлийг

хангахад чиглэсэн орон нутгийн бодлогыг дэвшүүлэн тавьж, хэрэгжилтийг хангах нь хөтөлбөрийг боловсруулах нийтлэг үндэслэл болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Хүүхэд бүрийг эрүүл бие, саруул ухаан, бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, шийдвэр гаргах, ажиллаж амьдрах, өөрчлөлтөд дасан зохицох, насан туршдаа суралцах чадвартай, үндэсний хэл, соёл, ёс уламжлалаа эрхэмлэдэг, чадварлаг иргэн болгож төлөвшүүлэх нөхцөл бүрдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав. Хөтөлбөрийн зарчим

3.1. Хөтөлбөрийн агуулга, хэрэгжилт нь нийгмийн хөгжил, орон нутгийн онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн уян хатан байх.

3.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь нээлттэй, хүртээмжтэй, тэгш байдлыг хангасан байх

3.3. Иргэд олон нийтийн бүтээлч хамтын ажиллагааг эрхэмлэсэн, сонирхогч бүх талын дэмжлэгт түшиглэсэн байх

Дөрөв. Хөтөлбөрийн хугацаа

4.1. Хөтөлбөрийг Монгол улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан 2017-2020 онд хэрэгжүүлнэ.

Тав. Хамрах хүрээ:

- Хүүхэд багачууд, оюутан суралцагчид
- Багш сурган хүмүүжүүлэгчид, мэргэжилтэн, албан хаагчид
- Иргэд, төрийн болон ТББ-ууд

Зургаа . Хөтөлбөрийн бүтэц

“Чадварлаг Ховдчууд” хөтөлбөр нь “Чадварлаг Багш”, “Номын гэгээ”, “Авьяас”, гэсэн 3 дэд хөтөлбөрүүдээс бүрдэнэ.

Долоо.”Чадварлаг багш” дэд хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

7.1 Багшийг багаар ажиллах, харилцах, бие даан суралцах чадварыг хөгжүүлэх зорилтын хүрээнд :

- Багшлах боловсон хүчний мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх хэрэгцээний судалгаа хийх
- Багшийн ур чадварыг дээшлүүлэх олон талт хамтын ажиллагааны сайн дурын санаачлагыг дэмжих

- Багшийн ур чадвар, сурган хүмүүжүүлэх технологийн сан бүрдүүлэх
- Багшийн мэргэжил ур чадвараа дээшлүүлэх хэрэгцээний судалгаанд үндэслэн түвшин бүрт (багш өөрийгөө хөгжүүлэх, сургуулийн, аймгийн) тохирсон богино, урт хугацааны сургалтуудын хувилбарт хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх
- “Чадварлаг багш” сэдвээр олон нийтийн хэлэлцүүлэг, зөвлөгөөн, чуулга уулзалт, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг өрнүүлэх

7.2. Багшийн өөрийн нөөц бололцоогоо нээн илрүүлэх, харилцааны ур чадварыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

- Харилцан мэдээлэл, туршлага солилцдог, өөрсдийгөө хөгжүүлдэг мэдээллийн цахим сүлжээг хөгжүүлэх замаар багш хамтдаа хөгжих боломж бүрдүүлэх
- Ажлын байранд мэргэжлийн ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломж бүрдүүлсэн багшийн хөгжлийн төвүүдийг мэдээ, мэдээллээр хангах, мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах, ном, гарын авлага, цахим хичээл, цахим сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтын шинэлэг арга, тэргүүн туршлагаар дэмжих,
- Хүүхэд бүрийн авъяасыг нээн хөгжүүлэх чиглэлээр телевиз, интернэт, цахим хуудас нээн ажиллуулах, гадаад орон, дэлхий нийтийн туршлагыг судлах, хэрэгжүүлэх
- Сурган хүмүүжүүлэх өв уламжлал, хүүхдийг хөгжүүлэх арга ухаанд суурилсан хүүхэд хүмүүжүүлэх, хөгжүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагаанд багш, сурагч, эцэг эх, сонирхогч талуудын оролцоог бий болгох

7.3. Багшийн судлан шинжлэх, илтгэх, нөлөөлөх чадварыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд

- Хүүхдийг хөгжүүлэх төлөвшүүлэх, сурган хүмүүжүүлэх чиглэлээр үр дүнд хүрсэн багш нарын бүтээл, тэргүүн туршлагыг тодорхой шалгуур үзүүлэлтээр үнэлж, нийтийн хүртээл болгох
- Багшийн хөгжлийг дэмжих сургалт, судалгааг их дээд сургууль, БСУГ мэргэжилтэн судлаачидтай хамтран хэрэгжүүлэн зохион байгуулах
- Багшийн хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлийг судлах, түүнийг бууруулахад чиглэсэн нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах, үр дүнг сайжруулах

Найм. “Номын гэгээ” дэд хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

8.1. Сургуулийн өмнөх болон сургуулийн насны хүүхдийг ном унших сонирхолтой болгох, уншсан номынхоо агуулгыг баяжуулан бүтээлчээр сэтгэх, ярих, өөрсдөө туурвин бүтээх чадвар эзэмшүүлэх зорилтын хүрээнд:

- Аймгийн хүүхдийн уран бүтээлийн номтой болох
- “Уншихаа боливол сэтгэхээ болино” сурталчилгаа явуулах
- “Дараагийн хуудас” телевизийн цуврал нэвтрүүлэг явуулах
- Сурагчдын дунд эссээний уралдааныг зохион байгуулах
- Иргэдийн дунд хүүхдэд зориулсан уран бүтээлийн уралдаан явуулах

8.2. Хүүхэд залуучуудыг номд дуртай болгох, номыг бүтээлчээр унших чадвар эзэмшүүлэх чиглэлээр гэр бүл, зохиолчид, төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн хамтын ажиллагааны үр ашигтай хэлбэрийг тодорхойлж, үйл ажиллагааг уламжлал болгох зорилтын хүрээнд:

Төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын үйл ажиллагааг нэмэгдүүлэх "Дээлтэй, номтой Монгол", "Уянгын хязгаар" наадмыг зохион байгуулах

- БСУГ-ын дэргэдэх номын санг тогтмол ажиллуулах
- Санаачилгатай ажилласан иргэд, анги хамт олныг урамшуулах
- “Номын баяр”, “Номын чуулган”-ыг зохион байгуулах

Ес. “Авьяас” дэд хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

9.1. Хүүхдийн авьяасыг бүх талаар нээх, хөгжүүлэх, амжилтад хүргэх арга зүй, технологийг боловсруулж, түгээх зорилтын хүрээнд:

- "Хүүхдийн авьяасыг хөгжүүлэх боломж" төгсөх ангийнхны заавал сурах дуу, бүжгийн тайлант өдөрлөг зохион байгуулах
- “Их найрал-Ховд” хүүхдийн найрал дууны наадам
- Ардын дуу, бие биелгээ хосолсон театрчилсан урлагийн наадам зохион байгуулах
- Цэнгээнт бүжгийн "Их вальс" тэмцээн зохион байгуулах

- "Чадварлаг Ховдчууд"ардын урлагийн наадам зохион байгуулах

9.2. Хүүхэд бүрийг хөгжүүлэх таатай орчин бүрдүүлж багш, эцэг эх, олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилтын хүрээнд:

- Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн дунд /тв, сонин/ "Хүүхэд хөгжил-Шинэ хөгжил"цуврал нэвтрүүлэг
- Хүүхдийн туурвисан урлагийн бүтээл, зохион бүтээгчдийн фестивал зохион байгуулах
- Алтан өв" язгуур урлагийн хүүхдийн хамтлаг байгуулах
- Язгуур урлаг, яруу найраг,спортын клуб хичээллүүлэх

Арав. Хөтөлбөрийн санхүүжилт

10.1. Улсын төсөв.

10.2. Орон нутгийн төсөв. 160 сая, /Чадварлаг багш -62%, Номын гэгээ-19%, Авьяас-19%/

10.3. Олон улсын төсөл, хөтөлбөр.

10.4. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив

10.5. Бусад эх үүсвэр

Арван нэг. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

11.1 Хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах төлөвлөлт, иргэний нийгмийн байгууллага, төр болон төрийн бус байгууллагуудын оролцоо уялдаа холбоог хангах, хөтөлбөрийн үе шат бүрийн төлөвлөлт, хэрэгжилтийн хяналт – шинжилгээ, үнэлгээ хийх, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэхийг Боловсрол, соёл урлагийн газар зохион байгуулна.

11.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн хэлбэр нь сургалт, туршлага судлах, хүүхэд нэг бүрийг хөгжүүлж буй тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх үйл

ажиллагаа байх бөгөөд сургалтыг ажлын байрны, бүсчилсэн болон зайн сургалтын хэлбэрээр зохион байгуулна.

11.3. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулах сургалт, сурталчилгааны ажлын агуулга, арга зүй, төлөвлөгөөг Боловсрол, соёл, урлагийн газар, иргэний нийгмийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

Арван хоёр. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

12.1. Багшийн багаар ажиллах, харилцах, бие даан суралцах чадвар хөгжснөөр сургалтын байгууллага дээр сайхан харилцаа бий болж багш бүр өөрийн хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлагын хүрээнд хөгждөг болно.

12.2. Багшийн өөрийн нөөц бололцоогоо нээн илрүүлэх, харилцааны ур чадвар хөгжснөөр сургалтын байгууллагын багш нар өөрсдийн нөөц боломжоор хөгжих, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, цахим мэдээллийн санг өргөжүүлэх боломж бүрдэнэ.

12.3. Багшийн судлан шинжлэх, илтгэх, нөлөөлөх чадвар хөгжснөөр сургалтын байгууллага бүр ард иргэдэд нээлттэй ил тод болж, нийгэмд “БАГШ”-ийн нэр хүнд, үнэлэмж дээшилнэ.

12.4. Хүүхэд, залуучуудад ном унших, номыг эрхэмлэх үзэл санаа төлөвшин, ном уншсан хүүхдийн тоо нэмэгдсэн байна.

12.5. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд номын тусламжтайгаар сурах арга барил эзэмшүүлэх, бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээ төлөвшүүлэх замаар сурлагын амжилтыг ахиулах арга зүйн чадварыг багш нар эзэмшсэн байна.

12.6. Телевиз болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслүүд хүүхдэд ном уншихын ач холбогдлыг харуулсан уран бүтээлийг сонирхолтой хэлбэрээр туурвиж, гэр бүл, зохиолчид, төрийн болон төрийн бус байгууллага сургалтын байгууллагатай хамтран ажиллах хэвшил тогтсон байна.

12.7. Сурагчдын нуугдмал авьяасыг нээж илрүүлэх, хөгжүүлэх, эцэг эх, багш, иргэд, төрийн болон төрийн бус байгууллагуудын хүүхэд хөгжүүлэхэд чиглэгдсэн хамтын үйл ажиллагаа бүрдсэн байна.

12.8. Олон үндэстэн, угсаатны дуу хуур, өв соёлыг ирээдүй хойч үедээ өвлүүлэн хөгжүүлэх ажлын хүрээ өргөжсөн байна.

12.9. Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сонгон, секц, дугуйланг багш нарын боломж, санхүүгийн нөөц, анги танхимын хүрэлцээ зэргийг харгалзан бодит боломж дээрээ тулгуурлан хичээллүүлдэг болсон байна.

Арван гурав. Хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээ

13.1. Энэ хөтөлбөрт заасан сургалт, үйл ажиллагаанд хамрагдсан багш нар өөрийн болон сургалтын чанарын хөндлөнгийн үнэлгээг тогтмол хийх, үр дүнг ашиглана.

13.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрэх үр дүн болон шалгуур үзүүлэлтийн биелэлтээр гаргана.

13.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг Боловсрол соёл урлагийн газар хариуцаж, ЗДТГ хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллана.

“ЧАДВАРЛАГ БАГШ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2017.04.17

Ховд

д/д	Хийж ажлын чиглэл	гүйцэтгэх үндсэн	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Зорилго	Хүрэх үр дүн	Хугацаа				Хамрах хүрээ	Хариуцах эзэн	Төсөв
						2017	2018	2019	2020			
Зорилт 1. Багшийн багаар ажиллах, бие даан суралцах чадварыг хөгжүүлэх												
1	4.1.1. Багшлах боловсон хүчний мэргэжил, чадварыг дээшлүүлэх хэрэгцээний судалгаа хийх	Багшлах хүчний ур	Судалгаа хийх	Багшлах боловсон хүчний ур чадварын талаарх судалгаа хийж сургалтын хөтөлбөр, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ төлөвлөлт хийх	2020 он хүртэл багшлах боловсон хүчнийг чадваржуулах үйл ажиллагааны төлөвлөлтэй болно.	+				ЕБС, Цэцэрлэг	БСУГ	0
				Хөтөлбөрийг боловсруулах, үнэлэх сайжруулах	дэд хөтөлбөрийн төлөвлөлтийг сайжруулах	Дэд хөтөлбөрийн төлөвлөлт боловсруулагдана.			+		ЕБС, Цэцэрлэг	БСУГ

2	4.1.2 Багшийн ур чадварыг дээшлүүлэх олон талт хамтын ажиллагааны сайн дурын санаачлагыг дэмжих	"Багш солилцох" өдрүүд	Багшийн туршлагыг түгээх, судлан хэрэгжүүлэх	Сургууль, цэцэрлэг бүр 1-2 багшийг солилцон ажлуулж арга туршлагаа түгээсэн байна.	+	+	+	+	ЕБС, Цэцэрлэг	БСУГ,ЕБС, СӨБ	0
		Дэлхийн болон Монголын багш нарын өдрийг тэмдэглэх	Багшийн нэр хүнд үнэлэмжийг нэмэгдүүлэх, шагнаж урамшуулах	Амжилт гаргасан багш нар шагнагдсан байна.	+	+	+	+	ЕБС, Цэцэрлэг	ЗДТГ, БСУГ	40000.0
3	4.1.3 Багшийн ур чадвар, сурган хүмүүжүүлэх технологийн сан бүрдүүлэх	Тэргүүлэх мэргэжлийн зэрэгтэй багш нарын цахим сан	Тэргүүлэх мэргэжлийн зэрэгтэй багш нарын технологийн сан бий болгох	Тэргүүлэх мэргэжлийн зэргийн үүрэг, хариуцлага нэмэгдэж манлайлал бий болсон байна.		+	+	+	ЕБС, Цэцэрлэг	БСУГ, ЕБС, СӨБ	5000.0
4	4.1.4 Багшийн мэргэжил ур чадвараа дээшлүүлэх хэрэгцээний судалгаанд үндэслэн	2, 3, 4 дэх жилдээ багшилж буй багш нарын үндсэн сургалт	орон нутгийн үндсэн сургалтыг чанартай зохион байгуулах	2,3,4 дэх жилдээ багшилж буй багш нар үндсэн сургалтад хамрагдана.	+	+	+	+	ЕБС, цэцэрлэг	БСУГ, ЕБС, СӨБ	30000.0

	түвшин бүрт (багш өөрийгөө хөгжүүлэх, сургуулийн, аймгийн) тохирсон богино, урт хугацааны сургалтуудын хувилбарт хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй сургалт	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш нарыг бэлтгэх	Сургууль бүрд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш бэлтгэгдэнэ.	+		+		ЕБС, цэцэрлэг	БСУГ, ГБХЗХГ	1500.0
5	4.1.5 “Чадварлаг багш” сэдвээр олон нийтийн хэлэлцүүлэг, зөвлөгөөн, чуулга уулзалт, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг өрнүүлэх	Залуу багш нарын чуулга, уулзалт	Залуу багш нарын багшлахуйд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх	Залуу багш нарын сайн дурын байгууллагын үйл ажиллагаа идвэхжсэн байна.	+				ЕБС, Цэцэрлэг	БСУГ	0
		Тэргүүлэх мэргэжлийн зэрэгтэй багш нарын чуулган	Тэргүүлэх мэргэжлийн зэрэгтэй багш нарын манлайллыг бий болгох	Тэргүүлэх мэргэжлийн зэрэгтэй багш нар үйл ажиллагаа идэвхжинэ.		+				БСУГ	
		Ахмад багш нарын 3 дугаар зөвлөгөөн	Ахмад багш нарын чуулган					+			БСУГ, Ахмад багш нарын эрдмийн оргил

Зорилт 2. Багшийн өөрийн нөөц бололцоогоо нээн илрүүлэх, харилцааны ур чадварыг нэмэгдүүлэх

6	4.2.1 Харилцан мэдээлэл, туршлага солилцдог, өөрсдийгөө хөгжүүлдэг мэдээллийн цахим сүлжээг хөгжүүлэх замаар багш хамтдаа хөгжих боломж бүрдүүлэх	Хичээлийн судалгаа хийх.	Сургалтын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг илрүүлэх	Сургалтын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал шийдвэрлэгдэнэ.	жилийн туршид				ЕБС, Цэцэрлэг	Мэргэжилтнүүд	0
7	4.2.2 Ажлын байранд мэргэжлийн ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломж бүрдүүлсэн багшийн хөгжлийн төвүүдийг мэдээ, мэдээллээр хангах, мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах, ном, гарын авлага, цахим хичээл, цахим сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтын шинэлэг арга, тэргүүн туршлагаар дэмжих,	Багшийн хөгжил төвийн номын санг баяжуулах	Багшийн хөгжил номын сан байгуулах	Номын сантай болсон байна.	+				БСУГ	Мэргэжилтнүүд	5000.0

8	4.2.3. Хүүхэд бүрийн авъяасыг нээн хөгжүүлэх чиглэлээр телевиз, интернэт, цахим хуудас нээн ажиллуулах, гадаад орон дэлхий нийтийн туршлагыг судлах, хэрэгжүүлэх	"Багшийн хөрөг" баримтат хөрөг нэвтрүүлэг хийх.	Ур чадвар, тэргүүн туршлагатай 20 багшийн хөрөг нэвтрүүлэг бэлтгэх, түгээх	Хөдөөгийн сургуулиас 10, аймгийн төвөөс 10 багш: СӨБ-3, ЕБС-3, Коллеж-2, НТБ-1, БСУГ-аас 1 багшийн хөрөг нэвтрүүлэг бий болно		+	+					5000.0
9	4.2.4 Сурган хүмүүжүүлэх өв уламжлал, хүүхдийг хөгжүүлэх арга ухаанд суурилсан хүүхэд хүмүүжүүлэх, хөгжүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагаанд багш, сурагч, эцэг эх, сонирхогч талуудын оролцоог бий болгох	Сайн хичээл, үйл ажиллагааны аймгийн зөвлөгөөн зохион байгуулах.	Сайн хичээл, үйл ажиллаганы аймгийн зөвлөгөөн зохион байгуулах	Бүс бүрд багш харилцан туршлагаа солилцож, арга зүй түгэн дэлгэрнэ	+	+	+	+	ЕБС, Цэцэрлэг	Мэргэжилтнүүд		4000.0
Зорилт 3. Багшийн судлан шинжлэх, илтгэх, нөлөөлөх чадварыг нэмэгдүүлэх												
10	4.3.1 Хүүхдийг	Эрдэм	Эрдэм	Багш нарын	+		+		ЕБС, Цэцэрлэг	Мэргэжилтнүүд		8000.0

	хөгжүүлэх төлөвшүүлэх, сурган хүмүүжүүлэх чиглэлээр үр дүнд хүрсэн багш нарын бүтээл, тэргүүн туршлагыг тодорхой шалгуур үзүүлэлтээр үнэлж, нийтийн хүртээл болгох	шинжилгээний илтгэл хэвлүүлэх	шинжилгээний чиглэлээр бичигдсэн бүтээлийг тодорхой шалгуурын хүрээнд эмхэтгэх	судалгааны бүтээл хэвлэгдсэн байна.								
11	4.3.2. Багшийн хөгжлийг дэмжих сургалт, судалгааг их дээд сургууль, БСУГ-ын мэргэжилтэн судлаачидтай хамтран хэрэгжүүлэн зохион байгуулах	Чадварлаг багш" судалгаа хийх.	Багшийг чадваржуулах, хөгжүүлэх судалгаа хийх	Багшийг хөгжүүлэх менежмент сайжирсан байна.	+		+		ЕБС, Цэцэрлэг	Мэргэжилтнүүд	1500.0	
12	4.3.3. Багшийн хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлийг судлах, түүнийг бууруулахад чиглэсэн нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах, үр дүнг	Эцэг эх, олон нийтийн оролцооны судалгаа хийх	Эцэг эх, олон нийтийн оролцоог бий болгох	Сургалтын байгууллага бүр нийт эцэг эхийн 75 хувийг сураглтын үйл ажиллагаанд хамруулж, түншлэлийн олон	+	+	+	+	ЕБС, Цэцэрлэг	Мэргэжилтнүүд	0	

сайжруулах			талт үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.							
Нийт санхүүжилт										100000.0

“НОМЫН ГЭГЭЭ” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийх ажлын чиглэл	Зорилго	Хүрэх үр дүн	Хугацаа				Хамрах хүрээ	Хариуцах эзэн	Төсөв /мян төг/
				2017	2018	2019	2020			
1	Аймгийн хүүхдийн уран бүтээлийн номтой болох	Хүүхдийн шилдэг бүтээлээр ном бүтээх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах	Ховд аймгийн хүүхдийн бүтээлийн "Бахархал-2.3" номтой болно.		+		+	ЕБС-ийн сурагчид, СӨБ-ийн хүүхэд	БСУГ, ЕБС, Цэцэрлэг	8000.0
2	“Уншихаа боливол сэтгэхээ болино” сурталчилгаа явуулах	Арга туршлага харилцан солилцох, түгээн дэлгэрүүлэх	Бие биенээсээ суралцана.	+	+	+	+	ЕБС, Цэцэрлэг	БСУГ, Ховд ТВ, Ховдын мэдээ сонин, вэб сайт	
3	"Дараагийн хуудас" телевизийн цуврал нэвтрүүлэг явуулах	Хүүхэд залуучуудыг номтой нөхөрлүүлэх, ном уншихад чиглэсэн хамтын ажиллагааг өргөжүүлэх.	Хүүхдийг номтой нөхөрлүүлэхийн зэрэгцээ, ном уншуулах, бүтээлчээр сэтгэх аргыг эзэмшсэн байна.	+	+	+	+	ЕБС-ийн сурагчид,	БСУГ, ЕБС,	1000.0

4	Сурагчдын дунд эссээний уралдааныг зохион байгуулах	Уншсан номоосоо суралцах, судлах, бүтээлчээр унших арга зүйг түгээн дэлгэрүүлэх	Мэдлэг оюун ухаанаа хөгжүүлэхэд номыг бүтээлчээр унших нь чухад гэсэн ойлголттой болсон байна.	+	+	+	+	ЕБС-ийн сурагчид,	БСУГ, ЕБС	1200.0
5	Төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын үйл ажиллагааг нэмэгдүүлэх "Дээлтэй номтой Монгол", "Уянгын хязгаар" наадмыг зохион байгуулах	Ном хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд байгууллага иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	Хүүхэд залуучуудыг номтой нөхөрлүүлэх, ном уншихад чиглэсэн хамтын ажиллагааг өргөжсөн байна.	+	+	+	+	Төрийн болон төрийн бус байгууллага	БСУГ, Нийтийн номын сан	2000.0
6	Иргэдийн дунд хүүхдэд зориулсан уран бүтээлийн уралдаан явуулах	Иргэдийг хүүхдийн ном бүтээхэд татан оролцуулах, уран бүтээлийн сантай болох, урамшуулах, сурталчлах	Хүүхдэд зориулсан бүтээлтэй болж, сан арвижна.	+	+	+	+	Иргэд	БСУГ	4000.0
7	Номын сангийн номын фондыг нэмэгдүүлж, "Ном миний найз" уралдаан зохион байгуулж тэргүүний уншигч сурагч анги хамт	БСУГ, сургуулиудын номын сан, хэрэгцээтэй номоор хангагдах, хамтран ажиллах.	Номын сан тогтмол үйл ажиллагаа явуулдаг болсон байна.	+	+	+	+	БСУГ, ЕБС, Цэцэрлэг	БСУГ	10000,0

	олныг шалгаруулан алдаршуулах										
8	Санаачилгатай ажилласан иргэд, анги хамт олныг урамшуулах	Сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, дэмжих, алдаршуулах	Ард иргэд, тэргүүний хамт олны туршлага олонд түгэж тэднээс суралцсан байна.	+	+	+	+	ЕБС, Цэцэрлэг	БСУГ	2000.0	
9	"Номын баяр", "Номын чуулган"-ыг зохион байгуулах	Өөрсдийн бүтээлээр бахархах, сурталчлах	Хүүхдэд ном унших, ном бүтээх, түүнийг эрхэмлэх үзэл төлөвшсөн байна.	+	+	+	+	ЕБС, Цэцэрлэг	БСУГ, Нийтийн номын сан	1800.0	
Нийт санхүүжилт										30000.0	

“АВЬЯАС” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийх ажлын чиглэл	Зорилго	Хүрэх үр дүн	Хугацаа				Хамрах хүрээ	Хариуцах эзэн	Төсөв /мян төг/
				2017	2018	2019	2020			
1	"Хүүхдийн авьяасыг хөгжүүлэх боломж" төгсөх ангийнхны заавал сурах дуу, бүжгийн нэгдсэн өдөрлөг зохион байгуулах	Төгсөх ангийн сурагчдийн дуу, хөгжим, бүжгийн авьяасыг хөгжүүлэх, дэмжих	Хүүхэд бүр олон угсаатны өв соёлоосоо суралцаж хөгжинө.	+	+	+	+	ЕБС-ийн ахлах ангийн сурагчид	БСУГ, ЕБС,	3200.0
2	Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн дунд /ТВ, сонин/ "Хүүхэд	Хүүхэд хөгжүүлэх санаачлагыг түгээн	Орон нутгийн хэвлэл мэдээллийн	+	+	+	+	Орон нутгийн	БСУГ, Орон нутгийн хэвлэл	3200.0

	хөгжил-Шинэ хөгжил" цуврал нэвтрүүлэг хийх	дэлгэрүүлэх	боловсролын салбар дахь оролцоо нэмэгдэнэ.					хэмжээнд	мэдээллийн байгууллага	
3	"Их найрал-Ховд" хүүхдийн найрал дууны наадам зохион байгуулах	Хүүхдийн дуулах авьяас ур чадварыг хөгжүүлэх	хүүхэд бүрийн авьяас хөгжиж төлөвших,гоо зүйн боловсролыг нийтэд суртачлана.		+		+	ЕБС-ийн сурагчид	БСУГ, ЕБС, Цэцэрлэг	1600.0
4	Ардын дуу, бие биелгээ хосолсон театрчилсан урлагийн наадам зохион байгуулах	Ардын урлагийн төрлүүдийг заан сургах үйл ажиллагааг дэмжих	Олон үндэстэн угсаатны урлаг соёлын үнэт өвийг өвлүүлэх, сурталчлах, түгээн дэлгэрүүлнэ.	+			+	ЕБС-ийн сурагчид, Цэцэрлэг	БСУГ, ЕБС, ХДТ	1600.0
5	Цэнгээнт бүжгийн "Их вальс" тэмцээн зохион байгуулах	Хүүхдийг хөгжүүлж буй шинэ санаачлагыг түгээн дэлгэрүүлэх	Хүүхдийн бүжиглэх авьяас, ур чадварыг хөгжүүлнэ.	+	+	+	+	ЕБС-ийн сурагчид, Цэцэрлэг,	БСУГ,ЕБС, СӨБ	3200.0
6	"Чадварлаг Ховдчууд" ардын урлагийн наадам зохион байгуулах	Авьяасаа нээж хөгжүүлж амжилтанд хүрсэн хүмүүсийг суртачлах, арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх	Хүүхэд багачууд өвлөн суралцаж, угсаатны өвийн онцлогийг таниж мэднэ.		+		+	ЕБС-ийн сурагчид,	БСУГ	1600.0

7	"Алтан өв" язгуур урлагийн хамтлаг байгуулах	Хүүхдийг өв уламжлалаас суралцан хөгжих үйл ажиллагаанд багш иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	Хүүхэд багачууд олон ястны өв уламжлалаас суралцан эзэмшинэ.	+		+		БСУГ, ЕБС, Цэцэрлэг	БСУГ	1600.0
8	Язгуур урлаг, яруу найраг, спортын клуб хичээллүүлэх	Хүүхэд залуусын урлаг, спортын авьяасыг хөгжүүлэх	Хүүхэд бүрийн авьяас хөгжиж төлөвшинө.	+	+	+	+	ЕБС, Цэцэрлэг	БСУГ	2000.0
9	Хүүхдийн туурвисан урлагийн бүтээл, зохион бүтээгчдийн фестивал зохион байгуулах	Сургууль бүр хүүхдийн авьяас чадварыг нээх, оюуны спортыг хөгжүүлэх	Хүүхдийн оюун ухаан, авьяас чадвар хөгжинө.		+		+	ЕБС,	БСУГ,	2000.0
10	Оюун ухаан, хэл яриаг хөгжүүлэх сургалтыг зохион байгуулж, Оюун ухааны тэмцээнийг сурагчдын дунд насны ангилалаар зохион байгуулах	Хүүхдийн сэтгэх чадварыг сайжруулж, оюуны спортыг хөгжүүлэх, амьдрах ухаанд сургах	Хүүхдийн оюун ухаан, авьяас чадвар хөгжинө.	+	+	+	+	ЕБС,	БСУГ,	10000
Нийт санхүүжилт										30000.0